



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 6 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 349


Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.5, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 63/37 дугаар зөвлөмжийн 3.5.7-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ази, Европын дээд түвшний арван нэгдүгээр уулзалтын бэлтгэлийг хангах ажлын хүрээнд нисэхийн аюулгүй байдлыг хангах болон хилийн боомтын зориулалттай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, тусгай зориулалтын автомашин худалдан авах, нисэх буудлын зочдын танхимыг засварлах зэрэг бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заасан бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгүүлэхийг Зам, тээврийн сайд М.Зоригт, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Нямдаваа нарт зөвшөөрсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Гадаад хэргийн сайд

Л.ПҮРЭВСҮРЭН

Засгийн газрын 2016 оны 349 дүгээр
тогтоолын хавсралт

АЗИ, ЕВРОПЫН ДЭЭД ТҮВШНИЙ АРВАН НЭГДҮГЭЭР УУЛЗАЛТЫН
БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХУДАЛДАН АВАХ
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Тоо хэмжээ	Зарцуулах хөрөнгө (сая төгрөг)
1	Технологийн зориулалттай дунд оврын автобус (25 хүний суудалтай)	3	390.0
2	Агаарын хөлөг хөтлөх зориулалттай автомашин	2	130.0
3	Туулах чадвар сайтай автомашин	1	190.0
4	Агаарын хөлгийг шувуутай мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх, шувуу үргээх зориулалттай тоног төхөөрөмж	1	66.1
5	“Буянт-Ухаа” хилийн боомтын алба хаагчдын техник хэрэгсэл	-	150.0
6	“Чингис хаан” олон улсын нисэх буудлын Олон улсын хүндэт зочдын танхимын засвар	-	80.0
Нийт			1.006.1